

Хүрд ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2016.04.11-ний өдрийн хурлын тэмдэглэл

Хурал 2016.04.11-ний өдрийн 16.00 цагт компанийн хурлын заланд болов. Хуралд нийт 129625 ширхэг саналын эрх бүхий 10 хувьцаа эзэмшигч хүрэлцэн ирснээр хурлын ирц 95,83% болсон талаар тооллогын комисс танилцуулав.

Хуралд Б.Энхжаргал, Д.Дашдорж, Б.Эрдэнээ, Д.Мадгаа, Б.Мөнхбат, С.Эрдэнэчимэг, Ц.Эрдэнэсүх, Г.Алтансүх, Б.Бат-Эрдэнэ, Би Ди Сек ХХК-ийн төлөөлөл нарын 10 хувьцаа эзэмшигч оролцлоо.

Хурлын дэгийг танилцуулсны дараа хурлын даргаар Б.Мөнхбат, хурлын нарийн бичгийн даргаар Г.Гантуяа нарыг 100 хувийн саналаар сонгов.

Хурлын дарга Б.Мөнхбат хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулав.Үүнд:

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2015 оны үйл ажиллагааны тайлан танилцуулах
2. Компанийн 2015 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах
3. Компанийн 2016 оны бизнес төлөвлөгөө батлах.
4. Компанийн 2016 оны удирдлагын зардлыг батлах

Компанийн 2015 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хурлын дарга Б.Мөнхбат уншиж танилцуулав.

Компанийн тайлан, бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг танилцуулсны дараа хувьцаа эзэмшигчид санал бодлоо илэрхийлж ярилцав.

Г.Алтансүх- Компанийн үл хөдлөх хөрөнгөнд дахин үнэлгээ хийлгэх талаар ямар бодолтой байна. Хэтэрхий багаар үнэлэгдэж байгаа юм биш үү. Нарлаг зочид буудал ашигтай ажиллах боломжгүй юм байна. Цаашид энэ талаар ямар арга хэмжээ авах вэ?.Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих хуулийн дагуу 7,29 тэрбум төгрөгийг 11,69 тэрбум болгосон байна. Энэ ашиг мөн үү.

Б.Энхжаргал-Энэ бол борлуулалт. Татвар ногдуулах орлого.

Г.Алтансүх-Баянзүрх дүүрэгт барьж эхэлж байгаа орон сууц өнөөгийн нөхцөлд борлогдох болов уу.

Б.Энхжаргал-Дээрх асуултуудад тайлбар өгье гэж бодож байна.

1. Үл хөдлөх хөрөнгийн хувьд дахин үнэлгээ хийлгэх шаардлагагүй гэж бодож байна. Баянзүрх дүүргийн 30 машины гаражийн барилгыг 2015 оны хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн дагуу ашиглалтаас хасч, буулгасан. Суурийн дээр нь орон сууцны барилга барьж байгаа.

Манай контор байрлаж байгаа 2 давхар барилга, мөн хашаанд байгаа цехийн барилгууд, төмөр хийцийн цехийн барилга нь 1960-аад онд баригдсан хуучин барилгууд. Улаан булангийн барилга 1980-аад онд баригдсан.

Улаанбаатар хотын ~~орх~~ий төлөвлөгөөний дагуу контор, цехийн барилгуудын суурин дээр орон сууц баригдах юм. Тиймээс дахин үнэлгээ хийлгэх шаардлагагүй.

2. Нарлаг зочид буудлыг ашигтай ажиллуулах талаар арга хэмжээ авч байна. Барилга хот байгуулалтын яамны санаачлагаар Барилгачдын сувилал хэлбэрээр ажиллуулахаар ~~өлөвлөж~~, барилгын засварын ажлыг эхл үүлээд байна.

Сувилал ажиллуулсан тохиолдолд Засгийн газрын 2012 оны 185 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Ахмад настанд тусламж, ~~н~~гөлөлт үзүүлэх тухай журам"-д хамрагдах эрхтэй болсны дараа л ашигтай ажиллаж эхлэх байх.

Барилгын хувьд урьд нь сувилал ажиллаж байсан болохоор зориулалт нь таарч байгаа.

3. Орон сууцны талаар: 30х40 хэмжээтэй 30 машины гаражийн барилгыг буулгасан. Уг барилга маань балансад 1,5 сая ~~төгрөг~~ийн өртөгтэй байсан юм. Бид буулгасан тоосго, дам нуруу, модон материалыг буцаагаад борлуулж, орлого авснаар ямар ч алдалдал ~~үл~~ээхгүй болж байгаа юм. Шинээр барьж байгаа орон сууцны зургийг 100,0 ~~сая~~ ~~төгрөг~~өөр хийлгэсэн. Бүх техникийн нөхцөл, барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлөө аваад барилга угсралтын ажлаа эхлүүлж байна. Бид 2016 онд каркасаа бариад, 2017 онд ашиглалтанд оруулна. Захиалгыг 2017 оноос хийж эхэлнэ. Тиймээс эдийн засгийн ~~мндр~~элд өртөхгүйгээр барьчихна гэсэн бодол байна. Борлуулалт дээр анхаарч ажиллана.

Одоогоор зах зээл дээр борлогдоо ~~гүй~~ 300 00 орон сууц байгаа. ~~Хүн~~ авдаг байр барина гэж бодож байна. Борлуулалтыг бартер, бараа солилцоо гэх мэт олон янзаар хийх болно. Орон сууц борлуулах асуудлыг ТУЗ-ийн гишүүд, гүйцэтгэх удирдлага анхаарч ажиллана.

4. Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулийн талаар: Бетон эдлэлийн цехийн барилг ~~үл~~ хөдлөх хөрөнгөд 102,89 сая төгрөгөөр бүртгэсэн. Ил тодын хуулийг ~~орд~~сөнөөр 2014 оны борлуулалт 7,29 тэрбум төгрөгөөс 11,69 тэрбум төгрөг болж өссөн. Захиалагчийн хөрөнгө 32-р дансанд

бүртгэлтэй байсан. Барилга угсралтын ажил нь дуусаад 2-3 жил болсон барилгууд ч байсан. Тухайн үед 4 тэрбум төгрөгийг борлуулалт болгохоор 760 сая төгрөгийн НӨАТ болон ашгийн татвар төлөх болж татварын дарамтад орж, санхүүгийн хүндрэл учрах учраас бага багаар борлуулалт болгож явсан юм. Энэ хуулийн дагуу 4 тэрбум төгрөгийг борлуулалт болгосноор 760 сая төгрөгийн татвараас чөлөөлөгдсөн болно. Эдийн засгийн ил тод байдлыг дэмжих тухай хуулиар борлуулалт болгосон 4 тэрбум төгрөг нь 32 -р дансанд байсан захиалагчийн өглөг юм. Тэрнээс гаалиар нууж оруулж ирсэн ямар нэг бараа бүтээгдэхүүн биш юм.

Д.Дашдорж -Компанийн 2015 оны үйл ажиллагааны талаар ТУЗ-ийн тайланг сонслоо. 2015 оны үндсэн үйлдвэрлэлийн төлөвлөгөөт зорилт биелж, 2,406 тэрбум төгрөгийн борлуулалт, 414,1 сая төгрөгийн ашигтай ажиллажээ. Ногдол ашигт нэгж хувьцаанд 275 өгрөг олгохоор шийдвэрлэсэн байна. Удирдлагын зардлаас 22,6 сая өгрөг хэмнэсэн байна. Яг ямар зардлаас хэмнэснээ илтгэсэнгүй. ТУЗ-ийн дүгнэлтээс харахад мэргэжилтэй ажилтнуудыг сургах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэхэд 8 удаагийн сургалтад 6,28 сая төгрөг зарцуулсан байна. Бизнес өлөвлөгөө ний борлуулалтын орлого тасарсан ч ашгийн хэмжээ нэмэгдсэн байна.

Ажилтнуудын дундаж цалин буурсныг барилга угсралтын ажил буурсантай холбож ойлголоо.

Хийгдсэн ажлын үр дүнгээр удирдлагын урамшууллыг олгожээ.

Мөнгөн хөрөнгө банкинд байршуулж, 338,1 сая төгрөгийн хүүгийн орлого олсон нь сайн байна. Барилга угсралтын ажлын үнэ цэтгээд олж авч чадаагүй байгаа 1,6 тэрбум өгрөгийг олж авах талаар арга хэмжээ авч ажиллах хэрэгтэй байгаа юм байна.

Орон сууц барих асуудлыг дэмжиж байна. Компанийн бизнес өлөвлөгөөг батлах саналтай байна.

Нарлаг зочид буудал, автобааз алдагдалтай ажилласныг анхаарах.

Төмөр хийцийн цех, бетон эдлэлийн цехийн бие даасан үйл ажиллагааг жигдрүүлэх, дэмжлэг үзүүлэх, мэргэжилтэй ажилтнаар хангах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх талаар анхаарч ажиллах хэрэгтэй гэж бодож байна.

Мэргэжилтэй ажилтнуудыг сул зогсолтод ч цалинжуулж, ур чадварын нэмэгдэл олгох тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй.

Компанийн 2014 оны үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрч байна.

Мөн 2016 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах саналтай байна.

Б.Эрдэнээ-ТУЗ-өөс оруулж байгаа 2015 оны үйл ажиллагааны тайланг сонслоо. ТУЗ-ийн дүгнэлтэд 2015 оны ажлын гол үзүүлэлт ийг дүгнэж танилцууллаа.

Өнөөдөр манай нийгэм ямар байдалтай байгаа билээ. Цаашдаа ч улс орны эдийн засгийн байдал сайжрах төлөвгүй юм ярьж байна.

Ийм цагүед компани олон жилийн туршлага, нэр хүнддээ тулгуурлан хөл алдалгүй ажиллаж иржээ.

Зарим салбар, нэгд алдагдалтай ажилласан байна.Цаашид өөрчилж ажиллуулахаар өлөвлөж байгаа юм байна.Зочид буудлыг сувиллын зориулалтаар ажиллуулахад төлөг т өөрөмж шаардлагатай байх. Бялдаржуулах, эрүүлжүүлэх гэх мэт.

Барилга хот байгуулалтын яамнаас барилга угсралтын ажлын төсөвт өртгийн бүтцэд өөрчлөлт хийх бодлого байна уу?

Хөгжингүй орнуудад төсөвт өртгийн 70% нь цалин байдаг гэх юм. Ийм байдалд хүрвэл ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дөхөм болно.

Техникийн дэвшлийг барилгад нэвтрүүлж гэвэл төсөвт өртгийн бүтцэд өөрчлөлт оруулах хэрэгтэй гэж үздэг.Энэ талаар БХБЯ-наас баримталж байгаа бодлого байгаа юу?

2016 оны ноён нурууг босгож чаджээ. Тодорхой төлөвлөсөн ажлууд байна.

ТУЗ-ийн тайлан, 2016 оны бизнес өлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах саналтай байна.

Д.Мадгаа- Миний хувьд ТУЗ-ийн дүгнэлтийг сонслоо. Улс орон эдийн засгийн хямралтай байгаа үед компани яаж ажилласан, 2016 онд хэрхэн ажиллах талаар сонслоо.Энэ илтгэлийг дотор нь ажиллаж байгаа үний хувьд дэмжиж байна.

Б.Энхжаргал- Компанийн удирдлагын хувьд 2016 онд анхаарах гол асуудал бол ажил олох асуудал юм. Энэ онд 3-3,5 тэрбум төгрөгийн барилга угсралтын ажил хийх зорилттой.Өнөөдрийн байдлаар Сэлбийн 2183м DN400 мм-ийн зөөлөн ширмэн хоолойтой өөрийн урсгалтай ариутгах татуургын шугамын барилгын ажил-2 тэрбум төгрөгийн ажил бэлэн байна.

Улс, хот, дүрэг, орон нутгийн хөрөнгө оруулалттай тендер т оролцож 1-1,5 тэрбум төгрөгийн ажил олох бодолтой байна.

Улс, хотын хөрөнгө оруулалт багассан. Энэ онд Эрчим хүчний яамны хөрөнгө оруулалттай 2-хон ажил, Барилга хот байгуулалтын яамны хөрөнгө оруулалттай 4 -хон ажил байна.

Нийслэл, дүргийн хөрөнгө оруулалттай ажлууд нэлээд байна. Улсын хөрөнгө оруулалтын ихэнх хэсэг нь зам руу чиглэж байна. Сургууль,

цэцэрлэгийн барилгууд ихэвчлэн концессын гэрээгээр явагдаж байна. Энэ жил Улсын их хурлын сонгууль явагдана, засаг төр солигдоно.

Тиймээс концессын гэрээ рүү яаран орохгүй байхаар шийдэж байна.

Он гарсаар 14 тендерт оролцоод байна. Оролцсон тендерүүдээс түрүүчийн ажлууд ирж байна.

Бидний эн тэргүүний зорилт бол:

1. Барилга угралтын ажил олох
2. Байгууллагын авлагыг барагдуулах асуудал юм.

2015 оны эхэнд 3,8 тэрбум төгрөгийн авлагатай байсан бол одоо 1,6 тэрбум төгрөгийн авлагатай байгаа.

Алдагдалтай ажиллаж байгаа Нарлаг зочид буудлын зориулалтыг өөрчлөхөөр төлөвлөсөн. Түүнээс гадна ашиглалт муутай байгаа автобаазын нэгжүүдийг ашиглах шаардлагатай байна.

"Хүрд-Төмөр хийц" ХХК, "Хүрд-Бетон эдлэл" ХХК-ийг 2015 онд байгуулсан. Эдгээр ХХК бие даан ажиллах, ажлаа олох, өөрсдийгөө сурталчлах хэрэгтэй.

Автобаазыг тусад нь ажиллуулах болно. Гаднын захиалга авч ажиллуулах хэрэгтэй. Өнгөрсөн онд гэхэд 3 экскаватор ажилд гарсангүй.

Орон сууц барихтай холбоотойгоор хайрга, тоосго ~~өө~~ гэсэн хүн зөндөө ирж байна. Тэгэхэд автобааз ийм санаачлага гаргаж, гадны захиалга авч ажил үйлчилгээ эрхлэхгүй байна.

Орон сууц барихад 640м³ хайрга, 1600 тн цемент, 1000м³ элс, 3400м³ бетон хэрэгтэй байгаа. Бетон эдлэлийн үйлдвэрт 80 сая төгрөгөөр 40тн силос 2 ширхгийг барьсан. Бетон эдлэлийн үйлдвэр орон сууцны бетоныг үйлдвэрлэх шаардлагатай.

Бетон эдлэлийн үйлдвэрийн зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэж өгнө.

Төмөр хийцийн үйлдвэр санаачлагатай ажиллах хэрэгтэй. Одоогоор БЗУИ-100, НР-54 тогооны захиалга орж ирж байна. Зах зээлээ судлах, захиалга олох, шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх шаардлагатай.

Барилгын салбарын ажилчдын цалин 2009 онд батлагдсан тарифаар яваа. 6-р зэргийн ажилтны цалин 4101, 1-р зэргийн ажилтны цалин-2136 төгрөг.

Бид 6-р зэргийн ажилтны цалин 6000, 1-р зэргийн ажилтны цалин-3000 төгрөг болгох шаардлага тавьж байгаа.

Солонгос улсын ~~өд~~өлмөрийн институттай хамтарсан судалгаа гарч байгаа. Энэ чиглэлийн сургалтанд би 2 удаа хамрагдсан.

4-р сарын 18-нд Барилгын удирдах ажилтны өвлөгөөн болно. БХБЯ, Барилгын удирдах ажилтны өвлөгөөн дээр ажилтнуудын цалин хөлсний асуудлыг хөндөж ярих болно.

Одоогийн мөрдөж байгаа төсөвт өртгийн бүтцэд ажилтнуудын нийгмийн халамж, даатгалын асуудал орхигдсон байдаг.

Цалин хөлсний асуудлаар Барилгын үйлдвэрчний эвлэл /Батцогт/ -тэй холбоотой ажиллаж байна.

Ажил олгогч, ҮЭ хамтарсан цалин хөлсний талаар эвлэл ажиллаж байгаа бөгөөд уг зөвлөлийн бүрэлдэхүүнд би байгаа.

ТУЗ-ийн дүгнэлт, 2016 оны бизнес төлөвлөгөөг хамтарч боловсруулсан юм.

Та бүхэн бизнес төлөвлөгөө болон хэлэлцсэн асуудалд саналаа өгнө үү.

Хувьцаа эзэмшигчдийн санал хүмжлэлийг сонссоны дараа компанийн 2015 оны санхүүгийн тайлан, үйл ажиллагаанд өгсөн ТУЗ-ийн дүгнэлт, 2016 оны бизнес төлөвлөгөө, удирдлагын зардлыг батлах санал хураалт явагдаж, тооллогын комиссын дүг танилцуулсны дараа ТУЗ-ийн тогтоолыг батлах, санал хураалт явагдаж, 100 хувийн саналаар тус тус батлагдлаа.

Хурлыг хааж, хурлын дарга Б.Мөнхбат үг хэлснээр 17.30 цагт хурал дуусав.

Протокол хөтөлсөн:

Хурлын нарийн бичгийн дарга

Г.Гантуяа